

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журам, шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг уг хуульд нийцүүлэн зохицуулах шаардлага үүссэн.

2.Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3-т “шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр: 5.3.2-т шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгож, Шүүхийн захиргааны болон Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн сайжруулна.” гэж тусгасан.

3.Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Шүүгчийн эрх зүйн байдлыг шинэчлэн тогтоох, шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдсэн бусад шинэтгэлтэй нийцүүлэх, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж, “Үндсэн хуулиар олгогдсон шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг баталгаатай хангахын тулд шүүхийн захиргааны чиг үүрэгтэй холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүхийн захиргааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж, Шүүгчийн ёс зүйн хорооны эрх зүйн байдлыг боловсронгуй болгож, шүүгчийн ёс зүйн зөрчил, түүнд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох үүднээс Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж, “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, ажиллах журмыг нарийвчлан хуульчлах, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.” гэж тус тус тусгасан.

Ийнхүү шүүхийн багц хуулиудыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, түүнчлэн дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурлаас 2012 онд батлан хэрэгжүүлж байгаа Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд дурдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Ингэхдээ хууль тогтоомжийг хэрэглээ болон тогтвортой байлгах үүднээс эдгээр 4 хуулиар зохицуулсан харилцааг нэгтгэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараахь зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1.Шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт шүүгчдийн олонхи, Улсын дээд шүүхийн шүүгчдээс бүрдсэн Шүүгчдийн зөвлөлийг 2 жил тутамд ажиллуулахаар шинээр хуульчилж, энэхүү зөвлөлийн хуралдаанд оролцох анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн тоог тухайн шүүхийн шүүгчийн тоонд хувь тэнцүүлсэн байдлаар шүүх бүрээс төлөөлөл оролцох боломжтой байхаар тусгав.

Зөвлөл нь үйл ажиллагааныхаа болон төлөөлөгч сонгох журмыг батлах, Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, эгүүлэн татах, Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох, шүүгчдийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм.

Түүнчлэн Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчээс санал, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонхийн саналаар уг Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болохоор, зөвлөлийн хуралдаанд сонгогдсон шүүгчдийн талаас илүү нь оролцвол хүчинтэйд тооцохоор, мөн шүүгч биеэр оролцох боломжгүй тохиолдолд цахимаар санал өгч оролцох боломжоор хангах, зөвлөлийн хуралдааны зохион байгуулалтын асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцахаар тус тус тусгалаа.

2.Анхан болон давж заалдах шатны шүүхийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг тусгав.

3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэн томилох журам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлагыг тодорхой болгон тусгалаа. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүхээс сонгох таван гишүүдийг Шүүгчдийн зөвлөлөөс нууцаар санал хураан сонгох, бусад таван гишүүдийн тухайд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос гурвыг, Ерөнхийлөгч болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тус бүр нэг хүнийг нээлттэйгээр зохих журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж томилохоор тус тус тусгав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүдийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүгчдийн зөвлөлөөс сонгон шалгаруулж сонгож, томилохоор, ингэхдээ Шүүгчдийн зөвлөлөөс сонгогдсон 3 шүүгч болон Хууль зүйн байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс томилогдсон тус бүр 1 гишүүн орон тооны, бусад 5 гишүүд нь орон тооны бус байхаар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг орон тооны гишүүдээс нууц санал хураалтаар гишүүд дотроосоо олонхийн саналаар сонгохоор, мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой байхаар тус тус тусгалаа.

Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллуулах, бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүд нь шүүгчээр таваас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй байх, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, улс төрийн намын удирдах албан тушаал сүүлийн 5 жил хашиж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байхаар тус тус тавих шаардлагыг тодорхойлсон.

4.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсгээр нэмсэн Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг тодорхой болгон тусгалаа.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороог бие даан ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, улсын хэмжээнд нэг байхаар зохицуулж, одоогийн практикт үүссэн шүүгчийн ёс зүйн зөрчлийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн ёс зүйн хороо, Монголын Хуульчдын холбооны дэргэдэх Мэргэжлийн хариуцлагын хорооны аль алинд нь хандан шийдвэрлүүлэх боломжийг бий болгосон маргааны харьяаллын давхардлыг арилгаж бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороогоор шийдвэрлэж байх зохицуулалтыг тусгав.

Шүүхийн сахилгын хороо 9 гишүүнтэй байх одоогийн зохицуулалтыг хадгалж, харин Шүүхийн сахилгын хорооны эдгээр есөн гишүүнд Шүүгчдийн зөвлөлөөс 4, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 3, Ерөнхийлөгчөөс 1, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс 1 хүнийг тус тус сонгож, томилохоор, Шүүгчдийн зөвлөл, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс сонгож, томилсон тус бүр нэг гишүүн орон тооны, бусад нь орон тооны бус байхаар тусгалаа.

Шүүхийн сахилгын хорооны гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, шүүгч, хуульчаас бүрдэхээр хуульчилж, бүрэн эрхийн хугацааг 4 жил, нэг удаа улируулан сонгож болохоор тусгав.

Түүнчлэн Шүүхийн сахилгын хорооны орон тооны гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, орон тооны бус гишүүний ажилласан хугацааны урамшуулал олгох журмыг Улсын Их Хурал тогтоохоор, Шүүхийн Сахилгын хорооны ажлын албаны дарга, ажилтнуудын цалинг Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тус тус зохицууллаа.

Шүүхийн сахилгын хорооны ажлын албыг одоогийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдаж байгаа Шүүхийн ёс зүйн хорооны ажлын албыг шилжүүлэх байдлаар зохицуулах боломжтой.

5.Шүүхийн мэргэшлийн хороо нь орон тооны бус 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалж, харин гишүүдийн бүрэн эрхийн хугацаа

5 жил байсныг 4 жил болгон өөрчилж, гишүүдэд тавих шаардлагад эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан байхаар, мөн шүүгч, хуульчаас гадна эрдэмтэн байхаар тус тус нэмлээ.

Мэргэшлийн хорооны 6 гишүүн нь Улсын дээд шүүх болон давж заалдах шатны шүүгч байхаар, тэдгээрийг Шүүгчдийн зөвлөлөөс сонгож, Шүүхийн ерөнхий зөвлөлд санал болгохоор, Мэргэшлийн хорооны бусад гишүүдийг Шүүхийн ерөнхий зөвлөл сонгон шалгаруулж томилохоор тус тус тусгав.

Түүнчлэн Мэргэшлийн хорооны чиг үүрэгт одоо байгаа шүүгчид нэр дэвшигчээс хуульд заасан шалгалт авч, үнэлгээ өгөх бүрэн эрхээс гадна давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт гаргах бүрэн эрхийг нэмсэн болно.

6.Шүүгчид хүлээлгэх хариуцлага, үүнд шүүгчийн мэргэжлийн хариуцлагын зөрчлийг тогтоох асуудлыг хуульчилж, шүүгчид оногдуулах сахилгын шийтгэлийн төрлөөс зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулахыг хасаж, сахилгын шийтгэлийн төрөлд тодорхой хугацаагаар шүүгчийн ёс зүйн сургалтад суухыг даалгах, зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах төрлүүдийг нэмж тусгалаа.

7.Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэхүү хуульд заасан сахилгын зөрчлийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хянан шийдвэрлэх, давж заалдах журмаар гомдол гаргах, шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэхээр хуульчилж, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх процессийг дараах байдлаар тусгалаа.

Үүнд Сахилгын хороо иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг 60 хоногийн дотор шалгаж, хянан шийдвэрлэхээр ингэхдээ илтгэгч гишүүн гомдол, мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай асуудлыг шийдвэрлэсэн захирамж гаргахаар, гишүүний гаргасан захирамжийг хэргийн оролцогчоос эс зөвшөөрсөн гомдлыг Сахилгын хорооны хуралдаанаар илтгэгч гишүүнээс гадна 5 гишүүний ирцтэйгээр хуралдаж сахилгын хэрэг, гомдлыг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж магадлал гаргахаар тусгаж, харин Сахилгын хорооны магадлалыг эс зөвшөөрч гаргасан гомдлыг Улсын дээд шүүх танхим харгалзахгүйгээр 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд бүрэлдэхүүнийг нийт шүүгчдээс тохиолдлын журмаар Ерөнхий шүүгч сонгож томилохоор тус тус зохицууллаа.

Түүнчлэн гомдол, мэдээллийг хүлээн авах, хуваарилах, шалгах болон Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдаан явагдах процесс, Сахилгын хорооны ажлын алба, Сахилгын хорооны дарга гишүүд, сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүргийг хуульчилж, Сахилгын хороо бие даан ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэв.

8.Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гарсан үндэслэлийг хасаж, мөн шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлээс шүүгч гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх, зургаан сараас дээш хугацаагаар суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдлыг хасаж, энэ тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид чөлөө олгохоор тусгаж, харин энэхүү хугацаанаас дотогш буюу богино хугацааны чөлөөг Шүүгчдийн

зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн, тухайн шүүхийн ерөнхий шүүгч шийдвэрлэж байхаар тусгалаа.

9.Шүүхийн захиргаа буюу Тамгын газар, шүүхийн захиргааны ажилтны эрх зүйн байдлыг боловсронгуй болгон тусгав. Тухайлбал, шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байхаар хуульчилж, шүүгчийн туслахаар гурваас доошгүй жил ажилласан бол анхан шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруултад оролцох эрхтэй байх зохицуулалтыг тусгав. Энэ нь шүүхийн боловсон хүчний бодлогод эерэгээр нөлөөлөх, шүүгчийн ачааллыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

10.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж, анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд оролцох иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоо итгэлийг нэмэгдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчийн тоог нэмж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр ялгаатай нэрлэгдэж байгааг /дүгнэлт, санал/ нэг мөр болгон, иргэдийн төлөөлөгчийн хөлс олгох журамд албан томилолт, замын зардал зэрэг зохицуулалтыг нэмж иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн орчныг сайжруулахаар тусгав.

11.Шүүхийн эдийн засгийн баталгааг хангах үүднээс шүүхийн төсвийг бууруулахгүй байх зэрэг зохицуулалтыг тусгалаа.

12.Шүүхийн судалгаа, шинжилгээ, сургалтын асуудал хариуцах чиг үүрэг бүхий Судалгаа, сургалтын хүрээлэнг Улсын дээд шүүхийн дэргэд байлган, уг хүрээлэнгийн бүтэц, орон тоо, чиг үүрэг, ажиллах журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батлахаар, түүнчлэн шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны мэргэшлийг дээшлүүлэх сургалтыг мөн Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулахаар тусгав.

Уг судалгаа, сургалтын хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллахаар хуулийн төсөлд тусгасантай холбогдуулан Улсын дээд шүүхэд цоо шинээр бүтэц бий болгох шаардлагагүй бөгөөд тус шүүхийн бүтцэд одоо байгаа нэгжийг өргөжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой юм.

13.Хуулийн төсөлд шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэх асуудалд тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид дундаасаа сонгох, Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд оролцох тухайн шүүхийн шүүгчдийн төлөөллийг сонгох, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хуваарилах журмыг батлах чиг үүргийг нэмж тусгалаа.

14.Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг хянан шийдвэрлэх, бүх насаар нь хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хянан шийдвэрлэх эрхийг нэмж, эдгээр асуудлыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр тусгав.

15.Шүүх эрх мэдлийг мэргэшсэн тогтвортой байлгах үүднээс шүүгчид тавих болзол шаардлагыг өндөрсгөж, давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч анхан шатны шүүхийн шүүгчээр 6-аас доошгүй жил ажилласан байхаар, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч шүүгчээр 10 жил, эсхүл өмгөөлөгч, прокурорын аль нэгээр дагнан 10-аас доошгүй жил ажилласан байхаар, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхэд таваас доошгүй жил ажилласан байх, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчээр арван жил ажилласан байхаар өөрчилж тусгалаа.

Түүнчлэн Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс 3 жилийн хугацаагаар сонгож, 1 удаа улируулан томилж болохоор, танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч томилж, чөлөөлөхөөр тусгав. Мөн шүүгчээр томилогдон тангараг өргөхдөө Монгол Улсын Үндсэн хуульд өргөх агуулгыг шинээр тусгасан.

16.Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсантай холбогдуулан бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг хянан үзээд Сахилгын хороо түдгэлзүүлж, түдгэлзүүлсэн шийдвэрээ Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулахаар тусгаж Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж, харин Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны орон тооны гишүүнээр сонгогдсон, сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон үндэслэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэхээр тус тус тусгалаа.

17.Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотойгоор шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, аль нэг шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилуулах; шүүгчийн орон тоо цөөрсөн, шүүхийг татан буулгах болон өөрчлөн зохион байгуулахтай холбоотойгоор шүүгчийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүх, эсхүл өөр шүүхэд шилжүүлэн томилохоос Ерөнхийлөгч татгалзаж болохгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

18.Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтад шүүгч өөрийн хүсэлтээр шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойших 2 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, харин шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор тусгалаа.

19.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын албан тушаалд тавих шаардлагыг тодорхой болгон хуульчилж, хууль зүйн дээд боловсролтой, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 5 жилд улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй хэмээн тодорхойлов.

20.Шүүхээс үзүүлэх үйлчилгээг цахимаар зохион байгуулах эрх зүйн орчны бүрдүүлэх үүднээс шүүх хуралдааны тодорхой үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа.

21.Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн захиргааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” 18 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” 19 дүгээр тогтоол зэрэг холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэж, шүүгч хараат бус болон хариуцлагатай байх эрх зүйн орчин улам боловсронгуй болж, улмаар иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө шүүхээр хамгаалуулах эрх улам бүр баталгаажна.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/229 дугаартай тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бүх шатны шүүхийн төлөөлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг байгууллагын төлөөлөл орсон болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад тус тус хийсэн бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болон хуулийн төсөлтэй холбоотойгоор гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хөндлөнгийн үнэлгээний багаар хийлгүүлж, зөвлөмжийг тусган ажиллалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан улсын төсөвт тодорхой хэмжээний зардал үүсэхээр зардлын тооцоогоор гарсан бөгөөд энэхүү зардалтай холбоотой зохицуулалтын үйлчлэх хугацааг 2021 оноос дагаж мөрдөхөөр, түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар хэрэгжүүлэх арга хэмжээ, шилжилтийн үеийн зохицуулалт зэрэг асуудлыг шийдвэрлэхээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, анхан болон давж заалдах шатны 41 шүүх, Шүүхийн ёс зүйн хорооны ажлын алба, Улсын ерөнхий

прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монгол Улсын шадар сайд, Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Барилга хот, байгуулалтын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нар болон эрдэмтэн, судлаачаас саналыг авч тусгасан. /Саналын товчоог хавсаргав/

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр байршуулсан бөгөөд үүний дагуу ирүүлсэн иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 10 гаруй саналыг хүлээн авч хуулийн төсөлд анхаарч тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР